# БУЛГАН  АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
# 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## БУЛГАН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛСИЙН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО: УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ** */Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.5,1.12,1.13, Булган аймгийн Засаг даргын" 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"* | | | | | | | |
| **Зорилт 1. Иновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.** | | | | | | | |
| 1 | 1.1.Тоон гарын үсэг нэвтрүүлэх | | Олгосон тоон гарын үсгийн тоо | - | Иргэдэд тоон гарын үсэг олгогдсон байна | Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022.05.01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Монгол Улсын 16 нас хүрсэн иргэнд тоон гарын үсэг олгох ажлыг эхлүүсэн. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд сумын улсын бүртгэгч нарт 2022.05.13-ны өдөр сургалт зохион байгуулж дадлага хийлгэн тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгч ажилласан. Тоон гарын үсгийн талаар 6 байгууллагын албан хаагчид болон иргэдэд мэдээлэл өгч нийт 1756 иргэнд тоон гарын үсэг олгосон. | 100 |
| 2 | 1.2.Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг олон | | -Сурталчилсан хэвлэл, | - | Улсын бүртгэлийн хууль тогтоомж, | 1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор улсын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтэд сурталчлах зорилгоор Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлах | | мэдээллийн хэрэгслийн төрөл<br><br>-Олон нийтэд сурталчилсан мэдээ, мэдээллийн тоо | | үйл ажиллагааг сурталчилж, иргэдийг мэдээ мэдээллээр хангаж, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. | бүртгэлийн хэлтсийн фэесбүүк,пэйж хуудас, burtgel.gov.mn сайтаар дамжуулан нийт 35 удаагийн мэдээ мэдээллийг хүргээд байна. Цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia үйлчилгээг ашиглах заавар, зөвлөмж, үйлчилгээг иргэд олон нийтэд хүргэх ажлыг эрчимжүүлж, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт 331 бүртгэлийг баталгаажуулсан байна.<br>2. 2022.03.23-ны өдөр Булган сумын ЗДТГ-с зохион байгуулсан төрийн үйлчилгээг иргэдэд сурталчлах "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгт оролцож иргэний үнэмлэх 28, гадаад паспорт 8, эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ 10 олгож, бүртгэлийн үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээллийг нийт 85 иргэн, хуулийн этгээдэд олголоо. | |
| **Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 3 | 2.1. Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх | - | -Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр,<br>-Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр, | 2021 оны эхний хагас жилд<br>-иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 3389, -хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 454, | Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд | Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 4712 бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 966 бүртгэл, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр 1885 бүртгэл нийт 7563 бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр үзүүлсэн үйлчилгээний тоо | -эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2630 бүртгэл хийгдсэн. | хүртээмжтэй хүрсэн байна. | | |
| 4 | 2.2.Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэлжүүлж, гэрчилгээ олгох | - | -Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэсэн тоо<br><br>-Олгосон гэрчилгээний тоо | 2021 оны эхний хагас жилд гадны аймаг нийслэлийн харьяа 4 салбар төлөөлөгчийн газар бүртгэж гэрчилгээ олгосон. | Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн бүртгэлтэй салбар төлөөлөгчийн газрыг урьд оны мөн үеэс 1%-иар нэмэгдүүлнэ. | Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн 4 газрыг бүртгэж гэрчилгээг олгосон. | 100 |
| 5 | 2.3.Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх | - | -Улсын бүртгэлтэй холбоотой олгосон мэдээлэл, лавлагаа, нотлох баримтын тоо;<br>-Эрхийн улсын түтгэлзүүлсэн бүртгэлийн тоо; | 2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэний улсын бүртгэлийн 1854, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 44, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 174 лавлагаа мэдээллийг тус тус олгосон. | Улсын бүртгэлтэй холбоотой үнэн зөв лавлагаа, мэдээлэл, нотлох баримтыг хуульд заасан хугацаанд олгосон байна. | Иргэний улсын бүртгэлийн 2468 лавлагаа, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 64 лавлагаа, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн 123 лавлагаа, нийт-2655 лавлагааг олгосон. | 100 |
| 6 | 2.4. Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн | - | -Эд хөрөнгийн эрхийн үйлчилгээ үзүүлж буй сумдын тоо | - | Сумдад бүртгэх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг | Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээ Хангал сум, Хишиг-Өндөр сумын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээний эрх 2022 оны 4 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээ үззүүлэх ажлыг эхлүүлэх | | -Сумын улсын бүртгэгчийн хөтөлсөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоо - | | үзүүлсэн байна. / Хангал, Хишиг-Өндөр сумдад/ | сарын 01-ний өдрөөс олгогдсон. Хангал сумын тойргийн сум Сэлэнгэ, Хишиг-Өндөр сумын тойргийн сум Могод, Гурванбулаг сумын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. | |
| 7 | 2.5.Улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн бичвэрийг цэгцлэх ажлыг зохион байгуулах. | - | Улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь цэгцэлсэн хаягийн бичвэрийн тоо. | - | Улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн бичвэрийг цэгцлэх ажлыг зохион байгуулсан байна | Хаягжуулалтын тухай хуулийн дагуу 16 сумын ИТХ-н тэргүүлэгчдийн "хаяг олгох тухай" тогтоолуудыг нэгтгэн хаягийн жагсаалтыг гарган МТГ-т хүргүүлж иргэний улсын бүртгэлийн үндсэн мэдээллийн санд нэмүүлсэн. Хаяг өөрчлөгдсөнтэй холбоотой иргэд энэ оны эхний хагас жилийн байдлаар 594 иргэн шинэ хаягруу шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэн хаягаа шинэчилсэн. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн бичвэрийг цэгцлэх ажлын хүрээнд мэдээллийн санд бүртгэлтэй боловч иргэн бүртгэлгүй 54 хаягийн жагсаалтийг иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж мэдээллийн санд хүчингүй болгуулсан. | 90 |
| 8 | 2.6. Улсын бүртгэлийн хэлтэст хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах. | - | Цахимжуулсан иргэний улсын бүртгэлийн тоо | - | 2022 онд хөтөлсөн ИУБ-ийг бүрэн цахимжуулсан байна. | Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хөтлөгдөж байгаа бүртгэлийн эх нотлох баримтыг тухай бүр цахимжуулан ажиллаж байна. Нийт 6311 хуудас баримтыг цахимжуулаад байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цахимжуулсан материалыг тухай бүр хянан ажиллаж байна. | |
| 9 | 2.7.Улсын бүртгэлийн үйлчилгээнд дундын мэдээллийн сан ашиглах | | ЭМГ-тай төрөлтийн бүртгэлийн мэдээлэл солилцсон тоо | Нас барсны бүртгэлийн олон улсын ангилал кодыг сүүлийн байдлаар авч, иргэний улсын бүртгэлд ашиглаж байна. | ЭМГ-тай төрсний бүртгэлийн мэдээлэл үнэн зөв солилцсон байна. | Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээнд төрөлтийн бүртгэл хөтлөхөд эрүүл мэндийн яамны төрөлтийн санд үндэслэн 321 хүүхдийн төрөлтийн бүртгэлийг бүртгээд байна. | 100 |
| 10 | 2.8.Хаягжуулалтын журмын хүрээнд хаяг шинэчлэгдсэн иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ солих ажлыг зохион байгуулах. | - | Үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн нэмэлт өөрчлөлт хийсэн бүртгэлийн тоо. | - | Хаяг шинэчлэгдсэний улмаас солих шаардлагатай эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ солих ажлыг 10 хувьд хүргэсэн байна. | Хаягжуулалтын журмын хүрээнд хаяг шинэчлэгдсэн иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 410 гэрчилгээ сольж олгосон байна. | 90 |
| 11 | 2.9.Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийг хэрэглээнд нэвтрүүлэх. | - | -Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо;<br>-Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо | - | Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэсэн байна. | ЭХЭУБГ-аас ирүүлсэн 2022.5.30-ны өдрийн 6/4730 чиглэлийн дагуу Банк, санхүүгийн байгууллага иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан барьцаа /ипотек/-ны гэрээ, гэрээний нэмэлт өөрчлөлтийг хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхдээ батлагдсан маягтын дагуу хамтран гаргасан хүсэлтийн хамт хүлээн авч бүртгэх ажлыг 2022.6.02-ны өдрөөс эхлэнхэрэгжүүлж байна. Нийт барьцаалбаргүй барьцааны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрээ - 17, барьцаалбартай барьцааны гэрээ - 12 бүртгэсэн. . | |
| 12 | 2.10.Нотариатчтай “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулах, дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл нийлүүлэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд нотариатч зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх. | - | -Дундын мэдээллийн сангаар дамжуулан нотариатын мэдээлэл шалгах системд нийлүүлсэн мэдээллийн тоо;<br>-Нотариатаар зуучлуулан эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн бүртгэлийн тоо. | -<br>. | -Дундын мэдээллийн сангаар дамжуулан нотариатын нийлүүлсэн мэдээллийг тухай бүр шалгаж, бүртгэсэн байна.<br>-Нотариатчаар зуучлуулан ЭХЭУБ хөтөлсөн байна. | Аймгийн нотариат ЭХЭУБГ-тай мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ байгуулаагүй байна. | 0 |
| 13 | 2.11.Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан мэдээлэл хүргүүлэх | | -Хууль тогтоомжийн дагуу мэдээ тайланг үнэн зөв гаргасан байх<br>-Мэдээ тайланг хугацааны хувьд хоцрогдолгүй хүргүүлэх | 2021 оны эхний хагас жилд хуулиар тогтоогдсон холбогдох газар, байгууллага, этгээдийг мэдээ мэдээллээр бүрэн хангаж ажилласан. | Холбогдох мэдээ мэдээллээр хангаж ажилласан байна. | Сар бүр үзүүлсэн үйлчилгээний тоо мэдээг гаргаж, хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлж ажилласан. | 100 |
| 14 | 2.12.Улсын бүртгэлийн архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийг нэгдсэн санд цахим хэлбэрээр хөтлөх | | -Цахим санг үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлсэн эсэх<br>-Цахим санд оруулсан архивын баримтын тоо | - | Архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтөлсөн байна. | Хугацаа болоогүй. | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүртгэл, мэдээллийн тоо | | | | |
| 15 | 2.13.Архивын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах | | -Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br>-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | -Төрийн архивын улсын үзлэгийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. | Архивын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хангадсан байна. | Архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлстийн даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу Иргэний улсын бүртгэлийн нэгдсэн тооллогын үйл ажиллагаа 95 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Архивын эх нотлох баримтыг хадгалах нягтруулсан шүүгээний багтаамжийг нэмэгдүүлэхээр 2 шүүгээнд тавцан нэмж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг байршуулсан. Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн эх нотлох баримтыг жагсаалтын дагуу хүлээн авч байршуулаад байна. Эд хөрөнийн эрхийн бүртгэлийн архивын хувийн хэргийн тусгаарлах хуудсыг салган, архивын нэгж болгон тусгаарлах тооллогын ажлыг эхлүүлэн улсын бүртгэгч нар хяналт хийж газрын 300, үл хөдлөх эд хөрөнгийн 55 хувийн хэргийн тусгаарлах хуудсыг салган архивын нэгж үүсгэсэн байна. | 70 |
| 16 | 2.14.Тамга, тэмдэг хэрэглэх эрх бүхий этгээдээс хураалгасан тамга, тэмдгийг төрийн | | Төрийн архивт шилжүүлсэн тамга тэмдгийн тоо | УБЕГ-ын даргын тушаалаар 1 | Хуулийн этгээдийн хэлбэрийн | Тамга, тэмдэг хэрэглэх эрх бүхий этгээдээс хураалгасан тамга, тэмдгийг 2022.06.30-ны өдрөөр | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | архивт шилжүүлэн хадгалуулах | | | индекс, 1 код батлагдсан. | индексийг батлуулж, мөрдсөн байна. | тасалбар болгон аймгийн архивын газарт шилжүүлнэ. | |
| 17 | 2.15.Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох | | -Хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны тоо<br>-Шүүх хуралдаанд оролцсон тоо<br>-Шийдвэрийн мэдээлэл | 2021 онд шүүхийн хэрэг маргаанд 1 удаа итгэмжлэгдсэн ажилтан томилогдон ажилласан. | Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаахэрэг маргаанд хууль тогтоомжийн дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон байна. | Хуулийн этгээдийн бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудлаар Захиргааны хэргийн 3 шүүх хуралдаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр улсын бүртгэгчид оролцож, шийдвэрлэгдсэн. | 60 |
| **Зорилт 3. Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал,нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 18 | 3.1.Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих. | - | -Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2021 оны хагас жилийн байдлаар нийт 425 нэгжийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 8 зөрчил илрүүлж арилгасан. | -Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг баталсан байна.<br>-Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу шалгалт хийсэн байна. | 2022 оны ХУБ-ын төлөвлөгөөний дагуу бүртгэлийн үйл ажиллагаанд байнгын болон түүвэрчилсэн нийт 528 бүртгэлд шалгалт хийж, эд хөрөнгийн 14, иргэний 48, нийт 62 дүгнэлт гаргасан. 16 сум 1 тосгон, ИБТ-н улсын бүртгэгч нараас олгосон 1101 лавлагаа, лавлагааны бүртгэлийн дэвтэрт хяналт шалгалт хийж зөрчлийн тэмдэглэл /ХША-2 маягтыг/ үйлдэн холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. | 100 |
| 19 | 3.2.Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн | - | -Зөрчилтэй иргэдийн тоо: | 2021 онд мэдээлийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 8 | Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн илэрсэн | 1.ИУБ-н цахим санг цэгцлэх ажлын хүрээнд зөрчилтэй бүртгэгдсэн иргэний мэдээлэлд засвар өөрчлөлт, нэмэлт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэдийн зөрчлийг арилгах | | -Зөрчлийг арилгасан тоо; | иргэн, ЭХЭУБ-н 3 иргэдийн зөрчлийг арилгах дүгнэлт гаргасан байна. арилгуулсан. Нийт 11 иргэний зөрчлийг арилгаад байна. | зөрчлийг 100% арилгасан байна. | өөрчлөлт оруулах 28 дүгнэлт, бүртгэлийг хүчингүй болгох 20, ЭХЭУБ-н талаар 14 дүгнэлт гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн. 2. ИУБГ-с ирүүлсэн чиглэл Цахимжуулсан ИУБн 298 бүртгэлд хяналт тавьж, - байна. 2.ЭХЭУБ-н програмд засвар өөрчлөлт оруулсан тайланг 7 хоног бүр улсын ахлах бүртгэгчээс авч хяналт тавин ажиллаж байна. | |
| 20 | 3.3.Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх | - | -Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн тоо -Зөрчлийг зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлэсэн тоо | 2021 оны эхний улирлын байдлаар Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 182 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 4500,0 мян.төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д харьяалуулсан зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчил шалган шийдвэрлэсэн хэрэг, материалыг хуульд заасан хугацаанд /нэн даруй/ холбогдох прокурорт хянуулан, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж ирүүлсэн байна. | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д харъяалуулан заасан зөрчлийн талаарх 143 гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 2.945.000 төгрөгний торгох шийтгэл оногдуулсан. Хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ажиллагааны мэдээг сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон 5 удаа мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох албан тушаалтанд хүргүүлээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | 3.4.Байгууллагын ББНШАЗК-ын үйл ажиллагаанд хяналт тавих, хэлтсийн 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлын зохион байгуулах ... | - | -Жагсаалтыг эцэслэн батлуулсан эсэх;<br>-Устгасан баримт бичгийн тоо; | Байгууллагын ББНШАЗК 2021.03.22-ны өдөр хуралдаж 2020 онд хадгалах хугацаа дууссан хадгаламжийн нэгж, ИУБ маягтуудын жагсаалтыг хянаж, 23 журнал, 9141 ИУБ-маягтуудыг нэгтгэн устгах бичгийн жагсаалт үйлдэн 2021.03.23-ны өдөр Нэгдсэн архивын газарт хүргүүлж ажилласан. | Жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдсөн байна. | Байгууллагын 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан 01 дүгээр сард ББНШК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулсан. | 70 |
| 22 | 3.5.Төрийн архивын 2021 оны улсын үзлэгийн дүгнэлтээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах | | Байгууллагын архивын нийтлэг журмыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг 60 хувьд хүргэх | Төрийн архивын2021 оны улсын үзлэгт амжилттай дүгнүүлсэн. | Арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Архивын байр, хадгаламжийн сан нь тавигдах шаардлагыг хангаж, баримт хадгалах тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд архивын байрны гэрлийн утсанд монтаж хийж гэрэлтүүлгийн шаардлагыг хангаж ажиллалаа. Мөн архивын байрны цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт, чийг дулаан хэмжих, тавиурын дугаар, орц гарцын тэмдэглэгээ, галын булан, бүртгэлийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэвтрийн хөтлөлт зэргийг хууль журмын дагуу гүйцэтгэж байна. | |
| 23 | 3.6.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих | - | -Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь;<br>-Мэдээ тайланг үнэн зөв гаргасан байдал; | 2021 оны эхний хагас жилийн байдлаар тус хэлтэст нийт 36 өргөдөл гомдол ирснийг 31 шийдвэрлэж хариуг өгсөн. 5 хугацаа болоогүй. Өргөдөл гомдлын хагас жилийн тайлан УБЕГ-т хугацаандаа хүргүүлсэн. Ирсэн өргөдөл гомдлыг ABLE програмд бүртгэж, хянан хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. | Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайланг УБЕГ, аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | Тус хэлтэс нь 12 дугаар сарын 01-ний байдлаар 93 өргөдөл, гомдлыг хүлээн авч 75 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч ажилласан бол хугацаа болоогүй 8 өргөдлийг хяналтад авч шийдвэрлэж байна. Ирсэн өргөдөл гомдлыг ABLE програмд бүртгэж, хянан хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. | 95 |
| 24 | 3.7.Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх | - | Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын | 2021 оны хагас жилд фэйсбүүк хуудас болон цахим хуудсанд 5 удаа байршуулсан. | Сар бүр мэдээлэл байршуулсан байна. | Эд хөрөнгийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэл, Иргэний улсын бүртгэлийн сар бүрийн инфографик мэдээллийг 5 удаа, тоон гарын үсэгтэй холбоотой инфографик мэдээллийг 1 удаа байршуулаад байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоо 12 | | | | |
| 25 | 3.8.Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөж, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах | Батлагдсан төсөв | -Төсвийн өр, авлага үүсгэсэн эсэх;<br>-Төрийн аудитын шалгалтаар зөрчилгүй ажилласан эсэх; | 2021 оны эхний хагас жилийн байдлаар 207,7 сая төгрөгийн санхүүжилт авч 187,4 сая төгрөгийг төсвийн хуваарийн дагуу зөв зохистой зарцуулж, цалингийн зардалд 5,9 сая төгрөгийн өр үүсээд байна. 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авч ажилласан. | Байгууллагын төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулж, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж, аудитын зөрчилгүй дүгнэлт авсан байна. | Байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан хийгдэж байна. Эхний 5 сарын байдлаар төсвийн гүйцэтгэлээр 174.8 сая төгрөг орж хөрөнгийг зүй зохистой зарцуулж, халаалт, цалингийн зарцуулалтад 26.0 сая төгрөгийн төсөв дутагдалтай. | 90 |
| 26 | 3.9.Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах | - | -Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо;<br>-Хугацаандаа байршуулсан эсэх; | 2021 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны цахим сайтад 64 мэдээлэл оруулахаас 64 мэдээллийг хуулийн | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна. | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 100 хувь хангаж, хоцроосон мэдээлэл байхгүй, үнэн зөв байршуулж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хугацаанд , үнэн зөв байршуулсан | | | |
| 27 | 3.10.Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, тогтмолжуулах | - | -Төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах; | Байгууллагын эд хөрөнгийн тооллого,тооцоо, хүчингүй болгосон үнэт цаасыг актлаж устгах, ашиглалтын хугацаа дууссан эд хөрөнгийг актлах зэрэг асуудлаар 1 удаа хуралдаж шийдвэр гаргаж ажилласан. | Өмч хамгаалах зөвлөлийн ажил тогтмолжсон байна. | 2022.02-р сард тооллогын комисс томилж үндсэн хөрөнгийн жагсаалтыг албан хаагчдын эд хогшлын карттай тулган тооллогын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ашиглалтын хугацаа дуусан эд хогшлын жагсаалтыг гарган актлах саналыг хүргүүлэхээр ажиллаж байна. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар иргэний улсын бүртгэлийн ашиглагдахгүй болсон үнэт цаас, гэрчилгээг бараа материалын жагсаалтаас хасч устгах ажлыг зохион байгуулж ажилласан. | 80 |
| **Зорилт 4. Олон улсын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 28 | 4.1.Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах | | Хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо | Ухаалаг засаг төслийн хүрээнд эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл цахимжиж, иргэний бүртгэлийн үйл ажиллагаа үргэлжлэн цахимжиж байна. | Ухаалаг засаг -2 төслийг хэрэгжүүлсэн байна. | Ухаалаг засаг төслийн хүрээнд эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл цахимжиж, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хөтлөгдөж байгаа бүртгэлийн эх нотлох баримтыг тухай бүр цахимжуулан ажиллаж байна. Нийт 6311 хуудас баримтыг цахимжуулаад байна. | 100 |
| **Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | 5.1.“Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2022”–ыг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах | - | -Сургалтын төлөвлөгөө батлагдсан эсэх;<br>-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь; | 2021 онд эхний хагас жилийн байдлаар 4 заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилт 100% хувийн биелэлттэй гарсан. | Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна. | Хэлтсийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар УБЕГ, Төрийн албаны зөвлөл болон бусад байгууллагаас зохион байгуулсан 68 удаагийн цахим сургалт, 7 удаагийн танхимын сургалтад албан хаагчдыг хамруулж хүний нөөц, сургалтын системд бүртгүүлэн үнэлгээ өгч ажилласан. УБХ-ээс сумдын улсын бүртгэгч болон албан хаагчдад 14 удаагийн цахим сургалт 5 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Сургалтанд албан хаагчдыг хамруулснаар бүртгэлийн алдаа зөрчил багасч, ажилдаа хандах хандлага дээшилсэн. | 95 |
| 30 | 5.2.Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах | - | -Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо 29<br>-Заавартай танилцсан албан хаагчийн тоо; | 2021 онд УБЕГ-аас болон бусад газраас зохион байгуулсан танхимын-1, онлайн 18 сургалтанд 29 албан хаагч бүрэн хамрагдсан | Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна. | УБЕГ-аас хүний нөөц, сургалтын системтэй холбоотой заавар, зөвлөмжийн талаарх сургалтад албан хаагчдыг хамруулсан. Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан сургалтуудад албан хаагчдыг бүрэн хамруулж хүний нөөц, сургалтын нэгдсэн системд үнэлгээ өгч ажиллаж байна. | 95 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга ......................... /Д.Дэлгэрсайхан/

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* **Нэгжийн дарга**

Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний
газрын дарга .............................. /Т.Гантөмөр/

*Тайлагнасан:* **Нэгжийн дарга**

Булган аймаг дахь Улсын бүртгэлийн
хэлтсийн дарга ........................./Ж.Ганболд/

*2022.06.10*